



## ДАРХАН ФОРУМ

**Дархан форум нь Тогтвортой Хөгжлийн Зорилгыг (ТХЗ) Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх хурдасгуур болно.**

Тогтвортой Хөгжлийн Зорилго гэдэг нь Дэлхий улсууд сайн дураар хэрэгжүүлэх НҮБ-аас баталсан 17 Зорилго бүхий Тогтвортой Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө юм. Энэхүү төлөвлөгөөг Монгол улсад хэрэгжүүлж буй явцын талаархи “Сайн Дурын Үндэсний Тойм мэдээ”-г Монгол Улсын Засгийн газар 2019 онд НҮБ-д илтгэсэн байдаг.

ТХЗорилго ямар түвшинд хүрээд байгааг илэрхийлэх гол хэмжүүр нь “Сайн дурын Үндэсний тойм мэдээ” юм.

2016 оноос хойш НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөс жил бүр зохион байгуулдаг “Тогтвортой хөгжлийн талаархи Улс төрийн дээд түвшний чуулга уулзалт/форум” дээр НҮБ-ийн гишүүн улс орнууд ТХЗорилгын ахиц/дэвшлийн тухай Үндэсний тойм мэдээгээ танилцуулж иржээ. 2019 онд “Сайн дурын Үндэсний тойм мэдээ”-г илтгэсэн 47 улсын нэг нь Монгол Улс болов.

Тогтвортой хөгжлийн 17 Зорилго, 169 Зорилт нь 2030 он гэхэд ядуурал, өлсгөлөнг арилгах, эх дэлхийгээ хамгаалах, шударга ёсыг дэмжих, ялгаатай болон тэгш бус байдлыг арилгах, хөгжил цэцэглэлтийг авчрах хүсэл эрмэлзлэлийг илэрхийлдэг.

Дэлхийн хэмжээний эдгээр 17 зорилготой уялдуулан дараагийн 15 жилд хэрэгжүүлэх улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн тухай стратегийн бодлогын баримт бичиг болох “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (МУТХҮБ-2030)-ийг боловсруулан 2016 онд УИХ



баталснаар Монгол Улс нь ТХ Зорилгыг эрт хэрэгжүүлэгч орнуудын нэг болсон юм.

Монгол Улсын Засгийн газар нь МУТХҮБ-2030-ийг 2016 оны 02 дугаар сард баталснаасаа хойш НҮБ-ын ТХ Зорилгыг үндэсний хөгжлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхээр хичээн ажиллаж байна.

МУТХҮБ-2030 -д эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдал болон сайн засаглалын хүрээнд Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг тодорхойлсон. Энэхүү бодлогын баримт бичиг нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилго-2030-тай ерөнхийдөө агуулгын хувьд давхцаж байгаа ба ТХ Зорилго-14 (Далай тэнгисийн нөөцийг хамгаалах) заалт нь Монгол Улсад шууд хамаарахгүй хэмээн тухайн үзэл баримтлалд хамруулаагүй ажээ.

Монгол Улсын Үндэсний хөгжлийн газар МУТХҮБ-2030-н хэрэгжилтэд хяналт тавьж, Монгол Улсын төрийн бодлоготой уялдуулах, түүнийг хэрэгжүүлэх суурь үзүүлэлтүүдийг тогтоож, зорилтуудыг тодорхойлох тухай Ерөнхий сайд болон УИХ-д тайлагнадаг хяналтын байгууллага юм. 2020 онд УИХ-аас баталсан “Монгол Улсын Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт цаашид МУТХҮБ-2030 хэрхэн хэрэгжүүлэх тухай тусгасан. “Алсын хараа-2050” хөтөлбөрийг 5 жил тутамд тодотгож байх юм.

Салбар яамд болон орон нутгийн удирдлагууд ТХЗорилгын хэрэгжилтийн мэдээллийг Үндэсний статистикийн хороогоор (ҮСХ) дамжуулан иргэдэд хүргэх ёстой боловч хязгаарлагдмал мэдээллийн нөөцөөс хамааран хангалттай хэрэгжээгүй.

Техникийн туслалцааны хөтөлбөрийн дагуу судалж үзэхэд Монгол улсад хэрэглэж болох нийт 233 төрлийн шалгуур үзүүлэлтээс 126-г нь гаргах боломжгүй байна.



Монгол Улсын хувьд улс орныг бүхэлд нь хамарсан ТХ Зорилгын шалгуур үзүүлэлтийг гаргахад чадамжийн зөрүүтэй байдал үүссэн байна хэмээн дүгнэгдээд байна. Үүнд:

1.

Мэдээлэл цуглуулах хамгийн сайн арга барилыг сонгох болон арга зүйг шийдэх алхам хийгдээгүй байна.

2.

Мэдээлэл цуглуулах, бодлогын зохицуулалт болон тайлагнах тогтолцоо тодорхой бус.

3.

Шинэлэг аргаар мэдээлэл цуглуулах аргыг хэрэглэх, хэрхэн хэрэгжүүлэх аргачлалыг судлах.

Монгол Улсын ТХ Зорилгын хэрэгжилтийг хурдасгахын тулд ТХ Зорилгыг төлөвлөх, нэгтгэх, хэрэгжүүлэх, тайлагнахад Засгийн газрын болон Орон нутгийн ЗДТГ-ын чадавхын зөрүүг арилгах нь тулгамдсан зорилт юм. 2030 он хүртэл ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд орон нутгийн эрх баригчдын үүрэг оролцоо чухал бөгөөд 17 зорилго, 169 зорилтыг хэрэгжүүлэхэд тэдний оролцоо зайлшгүй бөгөөд дээрх зорилтуудын 60 гаруй хувь нь орон нутгийн Засаг дарга нар болон удирдлагуудын хэрэгжүүлэх үүрэг хариуцлагатай холбоотой. Тиймээс ТХЗорилгыг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагын оролцоо болон манлайлал чухал ач холбогдолтой юм.

НАЙРАМДАЛ төслийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж буй Дархан форум нь аливаа намын харьяалалгүй, шинийг санаачлагч, засаглалын нээлттэй түншлэл зарчмын хүрээнд иргэд болон төрийн албан хаагчдыг илүү хариуцлагатай, найдвартай, хүртээмжтэй, шуурхай, ил тод болон шударга хамтын ажиллагаанд чиглүүлэн ажиллах болно.



**Чадамжийн зөрүүтэй байдлыг арилгах болон ТХ Зорилгын гол үзэл санааг түгээх замаар Дархан форум нь хэрхэн ТХ Зорилгыг хэрэгжүүлэх хурдасгуур болох тухай:**

**01**

Дархан-Уул аймгийн захиргаа болон төрийн байгууллагуудад ТХЗ-ыг хэрэгжүүлэх ач холбогдлын тухай илүү ойлголттой болгох

**02**

ТХЗ-уудыг хэрэгжүүлэх орчныг бүрдүүлэхийн тулд олон түвшинд хэлэлцэх олон талт хамтын ажиллагааны форум зохион байгуулах.

**03**

МУТХҮБ-2030 болон ТХЗ-2030 хүрээнд ТХЗ-ыг нутагшуулахад төлөвлөх, хэрэгжүүлэх мөн тайлагнах чиглэлээр Дархан-Уул аймгийн төрийн албан хаагчдын чадавхыг нэмэгдүүлэх.

**04**

Дархан хотын форумаар дамжуулан ТХЗ-ыг хэрэгжүүлэх түншлэлийг бий болгох, тэдгээрийг татан оролцуулах Дархан-Уул аймгийн удирдлагын багийг чадавхжуулах.

**05**

Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын түншүүд (ялангуяа Европын холбоо болон НҮБ)-ийн хүлээн зөвшөөрсөн ТХЗ-ын 16 дахь зорилгын хэрэгжилтэд анхааран ажиллах Орон нутгийн ажлын хэсэг байгуулах.



## ТХЗ-2030, МУТХУБ-2030 ба иргэдийн оролцоот засаглалыг хэрэгжүүлэх Дархан-Уул аймгийн стратеги төлөвлөгөөг Дархан форум хэрхэн гаргах вэ?

МУТХУБ-2030 болон ТХЗорилго 2030-ыг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын өгсөн амлалтад үндэслэн 2030 он хүртэл орон нутгийн онцлогт тохирсон ТХЗорилгыг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг гаргахын төлөө Дархан Форум хичээн ажиллана.

ДАРХАН ФОРУМ НЬ: \_\_\_\_\_

НАЙРАМДАЛ төслийг хэрэгжүүлэгч талуудад Тогтвортой хотуудыг хөгжүүлэхэд орон нутгийн удирдлагуудын түншлэл үүсгэх зорилгыг биелүүлэхэд нь хамтран ажиллах боломжийг олгох; Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын бодлого боловсруулагчийн үүргээ гүйцэтгэх чадавхыг дэмжих, иргэдэд төрийн үйлчилгээг (цахим засаглалыг оролцуулан) хүртээмжтэй болгох, Дархан-Уул аймагт бүсчилсэн хөгжлийн аргачлалыг сурталчлах.

Тэгш бус байдал, гадуурхалт, тусгаарлалтыг үүсгэж буй хүчин зүйл ба үр нөлөөнөөс урьдчилан сэргийлэхээс гадна эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, түр оршин суугчид, орон гэргүй иргэд зэрэг нийгмийн зорилтот бүлгийн хэрэгцээг шийдвэрлэх замаар хотын нийгмийн хүртээмжийг хангах. Түүнчлэн, форум нь хүйсийн тэгш эрх, найдвартай байдал, хуулийн хүртээмж, мэдээллийн ил тод байдал зэрэг тэгш хүртээмжтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх.



ДАРХАН ФОРУМ НЬ: \_\_\_\_\_

Иргэний нийгмийн байгууллага болон бусад орон нутгийн байгууллагуудад: Дархан-Уул аймгийн засаг захиргаатай хамтран ажиллаж, Дархан хот болон сумуудын хэмжээнд хүний эрхийг хангах, хуулийн хэрэгжилт, хариуцлага, ардчилал, эв нэгдэл тогтвортой байдлыг хэрэгжүүлэх боломж үүсгэх.

Хөгжлөөс хэн ч үлдэж, хоцрохгүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хүртээмжтэй төрийн үйлчилгээ, сайн засаглал, хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээ, тэгш бус байдлыг багасгах, эрхээ мэддэг байх зэрэг иргэдийн эрэлт хэрэгцээг хангах чиглэлээр Дархан-Уул аймгийн Стратегийн судалгааны төвийн үүргийг гүйцэтгэнэ.

НАЙРАМДАЛ төслийн хэрэгжилтээр дамжуулан ХААИС-ын Дархан салбар, болон Ардчилал ба Засаглалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Европын байгууллагууд, Олон Улсын байгууллагууд, зөвлөх компаниудтай хамтран Дархан-Уул аймгийг сайн засаглалын төв болгох, түүний чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

**Дархан хот нь ТХЗорилгод хүрсэн “үлгэр жишээ хот” хэрхэн болох вэ?**

Дэлхийн хүн амын 55% нь одоогоор хот суурин газарт амьдардаг. 2050 он гэхэд энэ хэмжээ 70%-д хүрч өснө гэсэн таамаглал байгаа бөгөөд ингэснээр хотжилт нь 21 дүгээр зууны хамгийн чухал чиг хандлага болж байна.



Хотууд нь ТХЗ-ыг нутагшуулах үйл ажиллагааны хурдасгуур хэмээн Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030 болон Хотжилтын шинэ хөтөлбөрт (New Urban Agenda) тусгасан байдаг.

Дархан хотын форум нь бодлого, хууль тогтоомж, сайн засаглал, төлөвлөлт, хотын эдийн засгийг хөгжүүлэх, дэд бүтцийн тогтвортой хөгжлийн асуудлаар болон Европ, Азийн Олон Улсын шинжээчидтэй хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулна.

#### ЕРӨНХИЙ ЗОРИЛТ: \_\_\_\_\_

Орон нутгийн түвшинд үр дүнтэй, иргэн төвтэй төрийн бодлого ба төсөл хэрэгжүүлэхэд чиглэсэн сайн засаглалыг төлөвшүүлэн чадавхжуулж, бэхжүүлнэ;

Тогтвортой хотуудын хөгжлийн гол цөм болох тэгш эрхийг хангаж, үл ялгаварлан Хэнийг ч үлдээж хоцроохгүйгээр ТХЗ-д нийцсэн тогтвортой хотжилт, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг хурдасгана.



## ТОДОРХОЙ ЗОРИЛТУУД: \_\_\_\_\_

Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас ТХЗорилго ба шалгуур үзүүлэлтийг Аймгийн бодлого төлөвлөлтөд тусгах замаар Үндсэн хууль, бусад хуулийн болон институцын бүрэн эрхийн хүрээнд ядууралтай тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэх чадамжийг нь бэхжүүлж, төгөлдөржүүлнэ.

Зөвлөх үйлчилгээ, чадавхижуулах хөтөлбөрөөр дамжуулан ТХ-ын 17 зорилгыг нутагшуулан Дархан-Уул аймгийн ЗДТГ-аас иргэдэд үйлчлэх төрийн үүргээ хэрэгжүүлэх ур чадвар, чадамжийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх.

ЗДТГ-ын төрийн үүргээ биелүүлэх, үйлчилгээ үзүүлэх боломжийг хэмжих, үнэлэх мөн үйл ажиллагааны алдаа, үр дүнгүй байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор судалгааны ажлыг эхлүүлж, тогтмолжуулах ба Европын хотуудын Бодлогын болон Төслийн хамтын ажиллагааны тэргүүн туршлагуудыг олж мэдэх/ нутагшуулах.

ИТХ-ын төлөөлөгчид, ЗДТГ, иргэд, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага зэрэг хотын засаглал дахь оролцогч талуудыг мэдээлэлээр хангах, мэдлэгтэй болгох зорилготой мэдээллийн системийг бий болгох; Хотын засаглал дахь менежментийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэхэд учирч буй үр ашиггүй байдлыг олж тогтоох, асуудлыг шийдвэрлэхийн тулд оролцогч талууд хотын удирдлагатай хамтран ажиллана.



Иргэдийн гомдлыг хүлээн авах механизмыг тасралтгүй шинэчлэж, ил тод болгохын тулд хариуцлагатай засаглалтай байхад дэмжлэг үзүүлэх (Нийтийн сонсголын тухай Монгол улсын хууль, Төрийн албаны тухай хууль-ыг болон бусад холбогдох хууль журмыг сурталчлах, нэмэлт оруулах санал гаргах гэх мэт).

Дархан-Уул аймгийн дунд хугацааны хөгжлийн стратегид тусгагдсан хөгжлийн стратеги, дэд хөтөлбөр, төслүүд иргэдэд хэрхэн хүрсэн тухай жил бүрийн тайланг хэрхэн гаргадаг талаар Дархан форумар дамжуулан бусад аймгуудын ЗДТГ-т багц зөвлөмж гаргах

Сонгогдсон төлөөлөгч, удирдах албан тушаалтнуудын чадавхийг бэхжүүлэх, засаглалын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Баг бүрээс сонгогдсон төлөөлөгчийн гүйцэтгэлийг хянахын тулд стандартчилсан матриц буюу засаглалын шалгуур үзүүлэлтийг бий болгох “Иргэдээ сонсох хуудас”-ыг нэвтрүүлж, албажуулах

Ардчилсан засаглал, хариуцлагын асуудалд анхаарлаа хандуулж, аймгийн захиргаанаас хотын захиргаанд олгосон эрх мэдлийн цар хүрээг хэмжигч Хотын засаглалын индексийг танилцуулах.



**ДАРХАН ФОРУМЫН ХҮРЭЭНД ТХЗ-ЫГ ДАРХАН-УУЛ АЙМАГТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГАРАХ ҮР ДҮН:**

| Ажлын багц   | Гарах үр дүн                                   | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|--------------|------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дархан форум | Үр дүн 1:<br>ТХЗ-ыг орон нутагт<br>хэрэгжүүлэх | <p><b>Үйл ажиллагаа 1.1:</b><br/>Дархан-Уул аймгийн ЗДТГ сумдын ЗДТГ, орон нутгийн иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ ТХЗ-ыг бодлого боловсруулахдаа тусгах замаар байгууллагын бүтэц, үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдлын журмыг боловсронгуй болгох ажлыг санаачлах</p> <p><b>Үйл ажиллагаа 1.2:</b><br/>ДФ болон Нутгийн удирдлагын үндэсний холбоогоор дамжуулан төрийн захиргааны төв</p> |



**ДАРХАН ФОРУМЫН ХҮРЭЭНД ТХЗ-ЫГ ДАРХАН-УУЛ АЙМАГТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГАРАХ ҮР ДҮН:**

| Ажлын багц   | Гарах үр дүн                                | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|--------------|---------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дархан форум | Үр дүн 1:<br>ТХЗ-ыг орон нутагт хэрэгжүүлэх | байгууллага, иргэд болон бусад холбогдох талуудтай яриа хэлцэл, зохицуулалт, солилцоог бий болгоход Дархан-Уул аймгийн ЗДТГ болон сумдыг татан оролцуулах механизмыг бий болгож, ажиллуулах. ДФ нь ТХЗ-ын үзэл баримтлал, мэдлэгийг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, орон нутгийн шилдэг туршлагыг тодорхойлох, аймгийн хэмжээнд сурталчлах үүрэгтэй. |



| Ажлын багц      | Гарах үр дүн                                   | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                     |
|-----------------|------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дархан<br>форум | Үр дүн 1:<br>ТХЗ-ыг орон нутагт<br>хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа 1.3:<br>Дунд хугацааны хөгжлийн<br>төлөвлөгөө, дэд хөтөлбөр,<br>төслүүдэд ТХЗ-уудыг<br>нэгтгэх. |



| Ажлын багц   | Гарах үр дүн                                                                                                                                                                                                                             | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                     |
|--------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дархан форум | <b>Үр дүн 2:</b><br>Дархан-Уул аймгийн ЗДТГ орон нутгийн түвшинд нөлөөлөх үндэсний / дэд салбарын бодлогыг хэрэгжүүлэх, түүнчлэн ТХЗ-ын хамтын платформуор дамжуулан үйлчилгээ үзүүлэхэд гүйцэтгэх үүргийг өргөжүүлэх, харуулах, хүргэх. | <b>Үйл ажиллагаа 2.1:</b><br>ТХЗ-уудын хяналтын самбар болон аймгийн түвшинд хамтран ашиглах боломжтой платформыг бий болгох. |



| Ажлын багц      | Гарах үр дүн                                                                                                                                                                              | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа                                                                                                                                                                                         |
|-----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дархан<br>форум | <b>Үр дүн 3:</b><br>Аймгийн төрийн<br>албан хаагчид болон<br>сонгогдсон төлөөлөгч<br>дийг Олон улсын<br>түвшинд хамтын<br>ажиллагаа<br>явуулах мэдлэг, ур<br>чадвартай болгоход<br>чиглэх | <b>Үйл ажиллагаа 3.1:</b><br>ТХЗ-ын хүрээнд хэрхэн<br>хамтран ажиллах тухай<br>сургалтын хөтөлбөр<br>бэлтгэх.<br><br><b>Үйл ажиллагаа 3.2:</b><br>ТХЗ-ын хүрээнд хэрхэн<br>хамтран ажиллах тухай<br>сургалт хийх. |
|                 | <b>Үр дүн 4:</b><br>ТХЗ төвтэй ажлын<br>хэсэг иргэдэд үзүүлэх<br>үйлчилгээг<br>сайжруулах<br>хэрэгцээний талаар<br>ДЕФ-ийн дэд<br>хороонд тайлагнаж<br>байна.                             | <b>Үйл ажиллагаа 4.1:</b><br>ДФ-ын хэмжээнд ТХЗ-ыг<br>хэрэгжүүлэх ажлын хэсэг<br>байгуулах                                                                                                                        |



## ДАРХАН ФОРУМЫН БҮТЭЦ

ДАРХАН ФОРУМ БАЙГУУЛАХ:

### Дархан Форумын удирдагч

#### Засаглалын салбар



Ээлтэй хот  
иргэдийн оролцоог  
дэмжих



Энх тайван шудрага  
ёсыг цогцлоох



Хөгжлийн төлөөх  
түншлэлийг  
бэхжүүлэх

#### Нийгмийн салбар



Ядуурлыг устгах



Өлсгөлөнг зогсоох



Эрүүл мэндийг  
дэмжих



Чанартай  
боловсролыг  
дэмжих



Жендрийн эрх, тэгш  
байдлыг хангах



Тэгш бус байдлыг  
бууруулах

#### Эдийн засгийн салбар



Эдийн засгийн  
өсөлт, баталгаат  
ажлын байрыг бий  
болгох



Инновац болон дэд  
бүтцийг бий болгох

#### Байгаль орчны салбар



Баталгаат ундны ус,  
ариун цэврийн  
байгууламжаар  
хангах.



Сэргээгдэх эрчим  
хүчийг нэмэгдүүлэх



Хариуцлагатай  
хэрэглээ



Уур амьсгалын  
өөрчлөлтийн үр  
нөлөөг багасгах



Хуурай газрын эко  
системийг  
хамгаалах



ДФ-НАЙРАМДАЛ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

| № | Үйл ажиллагаа                                                                 | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах мэргэжилтэн                                        |
|---|-------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------|
|   | ДФ-ыг байгуулах                                                               | 2022.11 сар         | Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг |
|   | Орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ДФ-ын дүрэм боловсруулах | 2022.12 сар         | Аймгийн ИТХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг |
|   | Дарханы төрийн албан хаагчдыг сургалт                                         | 2023.3-11 сар       | ЕДИЭТ, Дархан Форумын зохицуулах хороо                      |
|   | Дархан форум 1                                                                | 2023.02 сар         | Байгаль орчны салбар зөвлөл                                 |
|   | Дархан форум 2                                                                | 2023.04 сар         | Нийгмийн салбар зөвлөл                                      |



| № | Үйл ажиллагаа                                                     | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах мэргэжилтэн                                                 |
|---|-------------------------------------------------------------------|---------------------|----------------------------------------------------------------------|
|   | Дархан форум 3                                                    | 2023.06 сар         | Эдийн засгийн салбар зөвлөл                                          |
|   | Дархан форум 4                                                    | 2023.09 сар         | Засаглалын салбар зөвлөл                                             |
|   | Дархан форум 5                                                    | 2023.11 сар         | Дархан Форумын зохицуулах хороо, бусад салбарууд                     |
|   | Ил, тод хариуцлагатай, цахим засаглалыг дэмжих платформ хөгжүүлэх | 2023.2-7 сар        | ЕДИЭТ, Дархан Форумын зохицуулах хороо                               |
|   | ДФ-ыг сурталчлан таниулах яан зохион байгуулах                    | 2023.2-12 сар       | ЕДИЭТ, Дархан Форумын зохицуулах хороо, салбар зөвлөлүүд             |
|   | Дархан Форумын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгүүд                   | 1-12 сар            | Дархан Форумын зохицуулах хороо, салбар зөвлөлүүд, Хөгжлийн агентлаг |



## Алхам 1

**Асуудлаа олж харах / жишээ:**

- ① .....  
.....
- ② .....  
.....
- ③ .....  
.....
- ④ .....  
.....
- ⑤ .....  
.....
- ⑥ .....  
.....
- ⑦ .....  
.....
- ⑧ .....  
.....  
.....



## Алхам 1

### Асуудлаа олж харах

Бид өдөр тутамдаа тулгарч буй асуудлаа бодитоор олж харан, мэдээлэх бүрэн боломжтой. Асуудлыг мэдээлэхдээ бусдын нэр хүндэд халдахгүй, нэр цохож доромжлохгүй, хувь хүн дээр асуудал тавилгүйгээр мэдээлээрэй. Ингэснээр бид гарц, гаргалгааг тодорхойлж, хамтдаа арилгаж чадна. Та доорх жишээнүүдийн адилаар тулгамдаж буй асуудлуудаа илэрхийлж болно. Жишээ нь:

ИРГЭДИЙН  
САНАЛ, ГОМДОЛ



Иргэдийн санал  
гомдлын хариу  
ирдэггүй

ҮЕ ТЭНГИЙН  
ДЭЭРЭЛХЭЛ



Дунд сургуулийн  
сурагчдын дунд  
үе тэнгийн  
дээрэлхэл их  
байна.

ХОГ  
ХАЯГДАЛ



Ил задгай хог  
хаягдал их  
байна.

ЭЛЕКТРОН  
ТАМХИ



Дунд сургуулийн  
сурагчдын  
электрон тамхины  
хэрэглээ их  
байна.

ХОГ ТАТАН  
АВАЛТ



Хогийг тогтмол  
цагт татан авалт  
хийхгүй байна.

АЖЛЫН  
БАЙР



Шилжин ирж буй  
иргэдэд  
тогтвортой,  
баталгаат ажлын  
байр хомс байна

ХӨРСНИЙ  
БОХИРДОЛ



Гэр хорооллын  
бүсүүдэд хөрсний  
бохирдол  
нэмэгдэж байна.

ЗЭЭЛ  
САНХҮҮЖИЛТ



Шинээр бизнес  
эрхэлж буй  
иргэдэд олгох зээл  
санхүүжилтэд  
хамрагдаж  
чадахгүй байна.



## Алхам 2

## Асуудлаа дэвшүүлэх

Нэр: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Цахим шуудан: \_\_\_\_\_

Тулгамдаж буй асуудал (дэлгэрэнгүй):

.....

.....

.....

.....

.....

---

---

---

.....

---

---

---

Тулгамдаж буй  
асуудалтай холбоотой  
баталгаажуулах зураг:



## Таны санал болгох гарц, шийдэл:

A faint, stylized line drawing of a person's head and shoulders, facing right, overlaid on the left side of the page. The drawing is composed of simple, light blue lines and is partially cut off by the left edge of the page. It appears to be a sketch or a watermark.



## Асуудлыг хэнд, хэрхэн танилцуулах вэ?

Тулгамдаж буй асуудлын чиглэл: “байгаль орчин/засаглал/нийгэм/эдийн засаг”

Тулгамдаж буй асуудлын чиглэлийн нарийвчлал: / хог хаягдал, хот тохижилт, иргэдийн эрүүл мэнд аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн орчин, төрийн үйлчилгээ...г.м/

“Дархан Форум” нь Тогтвортой хөгжлийн зорилгуудыг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх хурдасгуур болно. “Алсын хараа-2050”, “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, болон Дархан-Уул аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтүүдтэй уялдуулан Дарханы хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2016 оны 2 дугаар сард УИХ-ын тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (ТХҮБ-2030)-ыг баталсан. Дэлхийн ТХЗ-ын 17 зорилго, 169 зорилттой манай улсын ТХҮБ-2030-ын 4 бүлэг, 44 зорилт нь уялддаг.

НАЙРАМДАЛ төсөл нь Дархан-Уул аймагт ТХЗ-уудыг хэрэгжүүлэхийн тулд “Нийгэм, Эдийн засаг, Байгаль Орчин, Засаглал” гэсэн 4 үндсэн хэсэгт хуваагдан иргэдийн дуу хоолой, хувь нэмэр, оролцоог хангахаар ажиллаж байна.

Иймд та тулгамдаж буй асуудал болон саналаа ТХЗ-уудыг хэрэгжүүлэх 4 хэсгийн 16 зорилгуудын алинтай нь нийцэж байгааг тунгаан сонгоорой.



## Алхам 3

Та дээрх 3 алхмыг гүйцэтгэсний дараа Дархан Форумын  
✉ [dcf@friendship.mn](mailto:dcf@friendship.mn) мэйл хаягаар илгээнэ үү.

**Цахимаар санал, хүсэлтээ өгөх бусад холбооснууд:**

Дархан-Уул аймгийн ИТХ:

🌐 <http://darkhan-uul.khural.mn/>

Дархан сумын ИТХ :

🌐 <http://darkhan.darkhan-uul.khural.mn/>

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар:

🌐 <http://darkhan.gov.mn/>

Иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах Цахим платформ тун удахгүй...

Иргэн та цахимаар саналаа өгөх боломжгүй бол Алхам 2 дээр дурдсан санал, зөвлөмж өгөх хуудасны дагуу бичиж, өөрийн харьяа багийн төв дээрх Дархан Форумын санал авах хайрцагт хийнэ үү.

(бусад холбогдох хаягийг 36-рхуудаснаас харна уу)



## Тэмдэглэл

This image shows a blank sheet of white paper with horizontal dotted lines for writing. On the right side, there are faint green outlines of geometric shapes, including triangles and rectangles.



## Алхам 4

### Асуудлыг судлах:

Дархан Форумын салбар зөвлөлийн дарга нар таны өргөдөл, саналтай танилцаж, асуудлын учир шалтгаан, хүчин зүйлс, шийдвэрлэж болох арга замыг судлан тогтооно. Ингэхдээ дэвшүүлсэн асуудлууд нь аймаг орон нутгийн бодлогын баримт бичигт хэрхэн туссан болон төсөв төлөвлөгөө, хэрэгжилт байгаа эсэхийг судлан, тодорхойлно. Иргэн та Дархан Форумын ажлын хэсэгтэй хамтран судалгаа хийх, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох боломжтой.





## Тэмдэглэл






## Алхам 5

### Асуудлыг олон талын оролцоотой хэлэлцэх

Дархан форумын салбар зөвлөлийн ажлын хэсэг нь таны дэвшүүлсэн асуудлыг “Дархан форумын” хуралдаанд танилцуулж, олон талын оролцоотойгоор шийдвэрлэх арга замыг тодорхойлно.



Дархан форум бол иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, орон нутгийн төр, захиргааны байгууллага, бодлого тодорхойлогчид хамтран байгаль, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх арга замыг тодорхойлох, хөгжлийн бодлого, стратегиа боловсруулахад хамтын ажиллагааг нь хангаж өгөх чиг үүрэг бүхий нийгмийн институт юм.



## Тэмдэглэл



## Алхам 6

### Асуудлыг шийдвэрлэх

Таны дэвшүүлсэн асуудлыг Дархан Форумаар хэлэлцэж, гарсан шийдвэрийг Дархан Форумын дарга хүлээн авч үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

- Дархан форумын дарга нь хуралд оролцохдоо оролцогч талуудын санал дүгнэлтүүд дээр үндэслэн асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй оролцоно
- ДФ-ын дарга дангаараа шийдвэр гаргах боломжгүй асуудлуудаар холбогдох байгууллагад чиг үүрэг өгөх, мэргэжлийн байгууллага болон ажлын хэсэгт төсөл хөтөлбөр боловсруулах үүрэг даалгавар өгч болно
- Салбар зөвлөлийн ажлын хэсэг Дархан Форумын хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргуулах, холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэх, шаардлага тавьж ажиллана
- Дархан форумын дарга нь гарсан шийдвэрийн дагуу иргэн, ажлын хэсэг, мэргэжлийн байгууллагын боловсруулсан төсөл хөтөлбөр, дүрэм журмыг ИТХ-д танилцуулж шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.



## Шийдвэр ба хэрэгжилтийн хяналт

Асуудал дэвшүүлсэн иргэн та болон Дархан форумын салбар зөвлөлийн ажлын хэсэг нь шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, явцын тайланг Дархан форумын бүх гишүүдийн зөвлөлдөх хурал дээр танилцуулна.

Дархан Форумын Хяналтын зөвлөл нь үйл ажиллагааны хэрэгжилтэд мөн хяналт тавьж ажиллана.


**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ** - Засаг даргын эрх, хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжгүй асуудлуудаар холбогдох ажлын хэсэг хөтөлбөр, журам боловсруулж ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА** - Форумын хуралд оролцохдоо оролцогч талуудын санал дүгнэлтүүд дээр үндэслэн асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй оролцох бөгөөд шууд шийдвэр гаргах боломжгүй асуудлуудаар холбогдох байгууллагад чиг үүрэг өгөх, төсөл хөтөлбөр боловсруулах үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Зохицуулах хорооны үйл ажиллагааг удирдаж, гадаад, дотоодод төлөөлнө.

**ДАРХАН ФОРУМ** - Тогтвортой хөгжлийн зорилгуудыг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх хурдасгуур болно. Дархан-Уул аймагт Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд “Нийгэм, Эдийн засаг, Байгаль Орчин, Засаглал” гэсэн 4 үндсэн салбар зөвлөл байгуулан иргэдийн дуу хоолой, хувь нэмэр, оролцоог хангахаар ажиллана.



## Алхам 7





## Алхам 7

**ЗОХИЦУУЛАХ ХОРОО** - Зохицуулах хороо нь Дархан форумын дарга, Дархан форумын чиглүүлэгч-2, салбарын ахлагч-4, хяналтын зөвлөлийн гишүүн-1, нарийн бичиг 1 нийт 9 хүн байна. Дархан форумын салбар зөвлөлийн ажлыг дэмжиж, чиглүүлж ажиллана.

**ХЯНАЛТЫН ХОРОО** – 5-аас илүүгүй гишүүнтэй байх ба Дархан форумын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

**ИРГЭДИЙН ИНДЭР** – Дархан Форумын үйл ажиллагааны нэг хэлбэр нээлттэй хэлэлцүүлэг байна. Дархан Форумын хуралдаан хооронд шаардлагатай үед “Иргэдийн индэр” зохион байгуулагдана. Иргэдийн индэр нь иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлыг сонсож шийдвэрлэх зорилготой, нээлттэй уулзалт ба иргэд индрээс санал, асуултаа тавих, Дархан хот, Дархан-Уул аймаг, DBS TV, Цэц.мн, RGB TV фэйс бүүк, пэйжээр шууд /live/, 7037-1212 утсаар тус тус дамжуулан иргэдээс асуулт, санал гомдол, шүүмжлэл хүлээн авч, аймгийн Засаг дарга болон албаны удирдлагууд шууд хариулт, мэдээлэл өгнө.

**ДАРХАН ЕВРОПЫН БҮС НУТГИЙН ФОРУМ (ДЕФ)** - Дархан Форумгаас гарсан шийдвэрийн хүрээнд боловсруулагдсан төсөл, хөтөлбөрийг хэлэлцэж, Европын орнуудын сайн туршлагуудыг нутагшуулах, олон улсын хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

**ЕВРОП-ДАРХАН ИННОВАЦ ЭНТРЕПРЕНЕРШИП ТӨВ (ЕДИЭТ)** – Дархан форум зохион байгуулахтай холбоотой ажлуудад арга зүйн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэн зөвлөн тусалж санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.



## Алхам 7

**ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ** – Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөл. Хөгжлийн агентлаг нь бүс нутгийн нийгэм эдийн засаг байгаль орчны тогтвортой, шинэлэг өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах, байгаль орчны амьдралын чанарыг сайжруулах хүрээнд хөгжлийн бодлого стратегийг тодорхойлж засаг дарга болон холбогдох алба хэлтэст санал болгох чиг үүрэгтэй ажиллана.

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ** – ИТХ нь иргэдийн санал хүсэлтийг өөрийн цахим хуудсуудаар авч хамтран ажиллана.

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР** – ЗДТГ нь иргэдийн санал хүсэлтийг бичгээр болон цахимаар авч хамтран ажиллана.

**БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛД** - Тухайн баг, хорооны сонгуулийн эрх бүхий иргэн бүр оролцох эрхтэй ба иргэдийн дэвшүүлсэн санал, санаачилгыг Дархан Форумд хүргүүлнэ. Дархан Форум нь хэлэлцүүлэх асуудлыг БИНХ-аар хэлэлцүүлж иргэдийн санал, хүсэлтийг нэгтгэн авна Мөн харьяа багийн төвүүдэд байрлах Дархан Форумын саналын хайрцагт бичгээр саналаа өгч болно.



## АСУУДЛЫН ШИЙДЭЛ БА ҮР ДҮН

Асуудлаа тодорхойлдог, мэдээлдэг, судалдаг, хэлэлцдэг, хамтын шийдлээ гаргадаг, хариуцлагатай хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоход Дархан хотын иргэн бүрийн оролцоо чухал юм. Дархан Форумаас гарсан зарим шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд ЕДИЭТөв нь Дархан Европын Форумд танилцуулж, олон улсын хөрөнгө оруулалт, санхүүжилт татах чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

### Дархан Форумаас гарах үр дүн:



Иргэн бүрийн  
оролцоо  
хангагдах  
нөхцөл бүрдэнэ



Иргэд, Нутгийн өөрөө  
удирдах (НӨУ), Төрийн  
захиргааны байгууллагууд  
хоорондын ажлын уялдаа  
холбоо сайжирна



Хариуцлагын тогтолцоо  
сайжирна Иргэний  
нийгмийн  
байгууллагуудын үйл  
ажиллагаа нягтарч,  
чадавхжина



Тогтвортой хөгжлийн  
зорилгуудыг хангах,  
орон нутагт  
нутагшуулах,  
хэрэгжүүлэх үйл явц  
сайжирна



ХОЛБОО БАРИХ: \_\_\_\_\_

✉ Дархан Форум – dcf@friendship.mn

### НАЙРАМДАЛ төсөл - Дархан Форумын хороодын гишүүд

| № | Хорооны нэр      | Нэр            | Албан тушаал                                                                         | Утас: /976/ |
|---|------------------|----------------|--------------------------------------------------------------------------------------|-------------|
| 1 | Зохицуулах хороо | Б.Азжаргал     | Зохицуулах хорооны дарга-ДУА-ийн Засаг дарга                                         | 99372070    |
| 2 |                  | Г.Бямбажав     | Чиглүүлэгч АШУУИС-н багш                                                             | 99071999    |
| 3 |                  | Т.Гэрэлцэцэг   | Чиглүүлэгч Цэц,мн сэтгүүлч                                                           | 95004499    |
| 4 |                  | Б.Ганбаяр      | Эдийн засгийн салбарын зөвлөлийн дарга, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дарга | 99008309    |
| 5 |                  | М.Сарнай       | Нийгмийн салбарын зөвлөлийн дарга, Цэгц ТББ Хайраас өвлөх хайр                       | 99907262    |
| 6 |                  | А.Соронзонболд | Засаглалын салбарын зөвлөлийн дарга, Иргэдийн төлөөлөгч                              | 89110247    |
| 7 |                  | М.Алимаа       | Байгаль орчны салбарын зөвлөлийн дарга, Дархан хоггүй ирээдүй” НҮТББ                 | 99002085    |
| 8 |                  | Л.Отгонбаяр    | Нарийн бичиг - Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт хариуцсан мэрэгжилтэн             | 99032637    |
| 9 |                  | Н.Наранбаатар  | Хяналтын хорооны дарга Топ электроникс ХХК-ийн захирал                               | 99084263    |
| 1 | Хяналтын хороо   | Н.Наранбаатар  | Хяналтын хорооны дарга Топ электроникс ХХК-ийн захирал                               | 99084263    |
| 2 |                  | Ч.Ганбаатар    | Гишүүн, Малчин                                                                       | 99377020    |
| 3 |                  | Д.Эрдэнэ-Очир  | Гишүүн, Иргэн                                                                        | 99062579    |
| 4 |                  | Д.Туяа         | Гишүүн, Багийн иргэдийн нийтийн хурал                                                | 99399361    |
| 5 |                  | Д.Энхжаргал    | Гишүүн, Ойн нөхөрлөлүүдийн холбоо                                                    | 99029042    |



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

| Дэд хөтөлбөрүүдийн нэр                                                                                        | Хэрэгжүүлэх хугацаа |
|---------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| Дархан-Уул аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл                                         | 2021-2025           |
| ДУА-ийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр                                                   | 2021-2024           |
| Дархан-Уул аймгийн ИТХ, тэргүүлэгчдээс бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үйл ажиллагааны үндсэн чиглэл | 2020-2024           |



## ДЭД ХӨТӨЛБӨРҮҮД

| Дэд хөтөлбөр                           | Хэрэгжүүлэх хугацаа |
|----------------------------------------|---------------------|
| Хүний хөгжил                           | 2017-2020           |
| Жендерийн тэгш байдлыг хангах          | 2021-2024           |
| Эрүүл Дархан                           | 2021-2024           |
| Ухаалаг Дархан                         | 2021-2024           |
| Халамжаас хөдөлмөрт                    | 2021-2024           |
| Боловсрол-2032                         | 2021-2032           |
| Ногоон Дархан-2032                     | 2021-2032           |
| Мал амьтны эрүүл мэнд                  | 2021-2024           |
| Тохилог хороолол-эко орчин             | 2017-2024           |
| Эрчим хүч хэмнэх                       | 2018-2022           |
| Орон сууц                              | 2021-2024           |
| Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих | 2019-2023           |
| Утаагүй Дархан                         | 2021-2024           |



ДЭД ХӨТӨЛБӨРҮҮД \_\_\_\_\_

| Дэд хөтөлбөр     | Хэрэгжүүлэх хугацаа |
|------------------|---------------------|
| Атар-4           | 2021-2024           |
| Шарилжгүй Дархан | 2021-2024           |
| Цэвэр хот        | 2021-2024           |

ТӨСЛҮҮД \_\_\_\_\_

| Төслүүдийн нэр                 | Хэрэгжүүлэх хугацаа |
|--------------------------------|---------------------|
| Эрүүл хүн                      | 2021-2024           |
| Оюутан эмч                     | 2021-2024           |
| Чадварлаг сувилагч             | 2021-2024           |
| Шилэн эмнэлэг                  | 2017-2020           |
| Цагийн ажил                    | 2021-2024           |
| Цэцэрлэгт хүрээлэнтэй сургууль | 2021-2024           |
| Чадварлаг багш                 | 2021-2024           |



## ТӨСЛҮҮД

| Төслүүдийн нэр | Хэрэгжүүлэх хугацаа |
|----------------|---------------------|
| Цахим Дархан   | 2021-2024           |
| Байшин         | 2021-2024           |
| Эко жорлон     | 2021-2025           |